



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар A/45


Улаанбаатар хот

Г “ШУТИС-д төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэх журам” батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 12.1.4, “ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.9.2, 4.14.7, 10.2 дахь заалт, Захирлын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-д төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ыг хавсралтаар баталж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
2. Журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай орлогыг холбогдох эх үүсвэрээс бүрдүүлэн ажиллахыг Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга (Д.Барсболд), эрдэм шинжилгээ хариуцсан ахлах нягтлан бодогч (Б.Мөнхцэнгэл) нарт зөвшөөрсүгэй.
3. Батлагдсан журмыг мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Д.Цолモンбаатар), бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төвүүдийн захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, ахлах нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ШУТИС-ийн ректорын 2012 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/69 дугаар тушаалаар батлагдсан “ШУТИС-ийн Технологийн сангийн журам”, ШУТИС-ийн захирлын 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн “ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, гэрээт ажил гүйцэтгэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай А/46 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



367040752



	ШУТИС-Д ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ ШУТИС-ЭШ-ЖУ05	Эхний хэвлэлт Өөрчилсөн огноо Өөрчлөлтийн дугаар	2012.04.19 2022.04.29 1
--	--	--	-------------------------------

ШУТИС-Д ТӨСӨЛ, ГЭРЭЭТ АЖИЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Боловсруулсан:

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИЙН ГАЗАР

Хянасан:

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИИ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ДЭД ЗӨВЛӨЛ,
ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЛБА

Дэмжсэн:

ШУТИС-ИЙН ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

Баталсан:

ШУТИС-ИЙН ЗАХИРАЛ



АГУУЛГА

АГУУЛГА	2
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ.....	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	3
ТАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	4
ЗУРГАА. СУДАЛГААГ ДЭМЖИХ ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР БҮРДҮҮЛЭХ	6
ДОЛОО. СУДАЛГААГ ДЭМЖИХ САНХҮҮЖИЛТ, ХУВААРИЛАЛТ	7
НАЙМ. ТӨСӨЛ, ГЭРЭЭТ АЖИЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ	9
ЕС. БУСАД ЗҮЙЛ.....	11
ХАВСРАЛТ 1: СУДАЛГААГ ДЭМЖИХ САНХҮҮЖИЛТИЙГ БҮРДҮҮЛЭХ, ТӨСӨВЛӨХ, ЗАРЦУУЛАХ ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ	12
ХАВСРАЛТ 2: ХОЛБОГДОХ МАЯГТ.....	13



НЭГ. НИЙТЛЭГҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журам нь ШУТИС-ийн нэгжүүдийн төсөл, гэрээт ажил, зөвлөх үйлчилгээ, түр сургалт зэрэг эрдэм шинжилгээ, инновацийн ажлыг хэрэгжүүлэх үндсэн зарчмыг тогтоох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах баримт бичиг болно.
- 1.2 Санхүүжилтийн олон талт эх үүсвэрээс судалгааны орлого бүрдүүлэх, улмаар судалгаа, инновацийн ажлыг дэмжин шинэ мэдлэгийг бий болгох үйл ажиллагааг санхүүжүүлэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Их сургуулийн эрдэм, шинжилгээ, инновацийн үйл ажиллагаанд оролцогч профессор, багш, судлаач, эрдэм шинжилгээний ажилтнууд болон сонирхогч талуудад хамаарна.
- 2.2 Судалгааг дэмжих дансанд төвлөрсөн орлогыг их сургуулийн эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаанд зарцуулах, ШУТИС-ийн нэр дээр гэрээ байгуулсан төсөл, гэрээт ажлыг хэрэгжүүлэх, үр дүнг хүлээлгэн өгөхтэй холбоотой үйл явцыг хамааруулна.

ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- 3.1 Засгийн газрын 2014 оны 301 тоот тогтоолын хавсралт "Шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх" журам;
- 3.2 БСШУС-ын сайдын 2016 оны А/319 дугаар тушаалын хавсралт "Шинжлэх ухаан, технологийн төслийн төсөвт өртөг, зардлыг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих" журам;
- 3.3 "ШУТИС-2030 Стратеги төлөвлөгөө" бодлогын баримт бичиг;
- 3.4 "ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн талаар баримтлах бодлого"
- 3.5 ШУТИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам.

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1 **Судалгааг дэмжих данс:** ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн бодлого, чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зориулалттай Эрдэм шинжилгээ, инновацийн газрын банкны харилцах дансыг;
- 4.2 **Судалгааны орлого:** Энэхүү журмын 6.2-т дурдсан эх үүсвэрээс бүрдсэн мөнгөн хөрөнгийг;
- 4.3 **Төсөв:** Тухайн онд батлагдсан орлого, зарлагын мөнгөн хөрөнгийг;
- 4.4 **Эргэн төлөгдөх санхүүжилт:** Тодорхой хугацааны дараа буцаан төлөх нөхцөлтэйгээр олгож байгаа судалгааг дэмжих мөнгөн хөрөнгийг;
- 4.5 **Буцалтгүй санхүүжилт:** Их сургуулийн зорилгод хүрэх, эрдэм шинжилгээ, инновацийг хөгжүүлэхэд чиглэгдсэн судалгааг дэмжих санхүүжилтийг;
- 4.6 **Төсөл:** Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг холбогдох захиалга, гэрээний үндсэн дээр онол, арга зүйн өндөр түвшинд гүйцэтгэж, захиалагчийн



- хэрэгцээ, шаардлагыг хангасан үр дүнд хүрэхээр гүйцэтгэж буй баримт бичгийг хэлнэ. Төслийг санхүүжүүлэгч байгууллагаас хамааран дараах хэлбэрүүдэд ангилна. Үүнд:
- 4.6.1 ШУТИС-ийн санхүүжилттэй төсөл (ШУТИС-ийн төсвийн хөрөнгөөс санхүүжилт олгосон тесөл, судалгааны ажлыг хэлнэ)
 - 4.6.2 Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилттэй төсөл (Улсын төсвийн хөрөнгөөр БШУЯ-ны ШУТС-гаар дамжуулан санхүүжүүлсэн төслийг хэлнэ)
 - 4.6.3 Бусад эх үүсвэрээс санхүүжилттэй төсөл (Төрийн захиргааны байгууллага, олон улсын болон гадаадын байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн санхүүжүүлсэн төслийг хэлнэ)
 - 4.7 **Гэрээт ажил:** Бизнесийн болон бусад аж ахуйн нэгж байгууллагуудын захиалгаар гэрээ байгуулан хэрэгжүүлэх даалгаварт, захиалгат ажлыг хэлнэ. Гэрээт ажлыг төрлөөр нь дараах хэлбэрүүдэд хуваана.
 - 4.7.1 Захиалгат ажил: Захиалагчийн даалгаварт асуудлыг шийдвэрлэх зорилгоор гүйцэтгэж буй төлбөрт ажил, үйлчилгээ
 - 4.7.2 Зөвлөх үйлчилгээ: Мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэргэшүүлэх түр сургалт явуулах, экспертиз хийх, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, тендерээр шалгарсан төлбөрт ажлыг хэрэгжүүлэх зэрэг ажлыг ойлгоно. - 4.8 **Төлбөр:** Их сургуулийн орчин, дэд бүтэц, цахилгаан, техник тоног төхөөрөмж, лаборатори, бусад материаллаг баазаар хангах, төслийн гэрээний бүртгэл, хяналт, тайлагнал, санхүү бүртгэл тооцооны үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор төслийн санхүүжилтэд тогтолцоогүй төсөвлөж буй энэ журмын 6.2.2-т заасан мөнгөн хөрөнгийг;
 - 4.9 **ШУТИС-ийн нэгж:** ШУТИС-ийн дүрмийн 3.1, 3.2-т заасан нэгжүүдийг;
 - 4.10 **Товчилсон үгийн тайлбар**
 - 4.10.1 ЭШХАЭ дэд захирал-Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал
 - 4.10.2 ЭШИГ-Эрдэм шинжилгээ, инновацийн газар
 - 4.10.3 ТДТ-Технологи дамжуулах төв
 - 4.10.4 ЭШХА нягтлан бодогч-Эрдэм шинжилгээ хариуцсан ахлах нягтлан бодогч
 - 4.10.5 ЭНБД-Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга
 - 4.10.6 БСНА нягтлан бодогч-Бүрэлдэхүүн сургууль, нэгжийн ахлах нягтлан бодогч
 - 4.10.7 ЭШИХА дэд зөвлөл-ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөл
 - 4.10.8 ЭШИ-Эрдэм шинжилгээ, инноваци

ТАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 5.1 ЭШХАЭ дэд захирал:
 - 5.1.1 Их сургуулийн эрдэм шинжилгээ, инновацийн бодлого боловсруулах, төлөвлөгөөг баталж, бүрэлдэхүүний болон харьяалах нэгжүүдийн ЭНБД нартай үр дүнгийн гэрээ байгуулах;
 - 5.1.2 Судалгааг дэмжих дансны эх үүсвэр бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
 - 5.1.3 ШУТИС-ийн нэрээр хэрэгжүүлэх төслийн гэрээг батлах, хэрэгжилтийг хангуулах, гэрээг дүгнэх, санхүүжүүлэгч, захиалагч байгууллагуудтай их сургуулийг төлөөлж харилцах;



- 5.1.4 Журмыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- 5.2 ЭШИГ болон ТДТ:
 - 5.2.1 Их сургуулийн бодлого, зорилттой уялдуулж Эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө, төсөв боловсруулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;
 - 5.2.2 ЭШИГ болон ТДТ нь ШУТИС-ийн судалгааны ажлыг дэмжих санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжүүлэх;
 - 5.2.3 Гадаад дотоодын байгууллага, их дээд сургуулиудтай судалгааны хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар төсөл, гэрээт ажлын тоо, дүнг нэмэгдүүлэх;
 - 5.2.4 ШУТИС-ийн нэгжүүдийн ЭШИ-ийн үйл ажиллагааг төлөвлөгөөнд суурилсан төсвийн төлөвлөлтийг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах;
 - 5.2.5 Төсөл хөтөлбөр, судалгааны грант, эрдэм шинжилгээний хурал, инновацийн арга хэмжээний удирдамж хөтөлбөр гаргаж зарлах, сонгон шалгаруулах, гэрээ байгуулах;
 - 5.2.6 Судалгааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд хүрээлэн, төв, лаборатори, судалгааны багийн (профессорын баг) үйл ажиллагааг бодлогоор дэмжих, багш судлаачдын судалгааны чадавхыг нэмэгдүүлэх замаар шинэ мэдлэг бий болгох, дамжуулах, здийн засгийн эргэлтэд оруулах, түүнийг түгээн дэлгэрүүлэх;
 - 5.2.7 ШУТИС-ийн нэгжүүдийн хэрэгжүүлж буй төслүүдийн тайлан, үр дүнг нэгтгэх, хяналт тавих, ЭШИ-ийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэж баталгаажуулах.
- 5.3 ЭШХА нягтлан бодогч:
 - 5.3.1 Энэхүү журмын 6.2-т дурьдсан эх үүсвэрүүдээс судалгааг дэмжих дансанд орлого бүрдүүлэх;
 - 5.3.2 Судалгааг дэмжих дансны орлого, зардлын төсвийг холбогдох нэгжүүдээс авч нэгтгэх, батлуулах;
 - 5.3.3 Судалгааг дэмжих дансны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хариуцаж гүйцэтгэх, дүн мэдээг нэгтгэх, тайлагнах;
 - 5.3.4 Судалгааг дэмжих дансны зардлын зарцуулалтыг хариуцаж бүрэлдэхүүн нэгжүүдэд холбогдох санхүүжилтийг олгох;
 - 5.3.5 Их сургуулийн ЭШИ-ийн үйл ажиллагааны төсвийн зарцуулалтад хяналт тавих;
 - 5.3.6 Энэхүү журмын 6.2.2-т заасан эх үүсвэрээс бүрдүүлсэн төлбөрийн 50 хувийг холбогдох бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгээс санхүүгийн хагас жил, жилийн эцэст шилжүүлэн авах;
- 5.4 ЭНБД:
 - 5.4.1 Их сургуулийн бодлого зорилттой уялдуулан өөрийн сургууль, хүрээлэнгийн салбар тэнхим, судалгааны баг, төв, лабораторийн ЭШИ-ийн төлөвлөгөөг нэгтгэж төлөвлөгөө, төсөв боловсруулах;
 - 5.4.2 ЭШИ-ийн батлагдсан төсвийг энэхүү журмын 7.2-7.13 дугаарт заасан чиглэлүүдээр зарцуулах, хэрэгжилт, үр дүнг ЭШИГ, ТДТ-д тайлагнах;
 - 5.4.3 Өөрийн сургууль, хүрээлэн дээр шинээр хэрэгжих төслийн гэрээг энэхүү журамд нийцүүлж бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих, эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэх, үр дүн тайлан мэдээг холбогдох нэгж, байгууллагад хүргүүлэх;



- 5.4.4 ЭШХАЭ дэд захирлаар үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээг батлуулж мөрдөх, хэрэгжилтийг тайлагнах.
- 5.5 БСНА нягтлан бодогч:
- 5.5.1 Бүрэлдэхүүн сургууль, нэгжийн ахлах ня-бо нь энэхүү журмын 6.2-т дурьдсан эх үүсвэрүүдээс бүрдүүлсэн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах;
- 5.5.2 Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнд хэрэгжүүлсэн төсөл, гэрээт ажлын нягтлан бодох бүртгэлийг хариуцаж гүйцэтгэх, хянах, тайлан дүн мэдээг нэгтгэж холбогдох нэгж, ЭШХА ня-бо-д хүргүүлэх;
- 5.5.3 Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн дансанд зөвхөн энэхүү журмын 4.6.2-т заасан ШУТСангаас бусад төсөл, гэрээт ажлын орлогыг хүлээн авч 6.2.2-т зааснаар тооцож суутгана. Суутгасан төлбөрийн 50 хувийг судалгааг дэмжих дансанд санхүүгийн хагас жил, жилийн эцэст шилжүүлэх;
- 5.5.4 Энэхүү журмын төлбөрийн орлогод үндэслэн ирэх оны эрдэм шинжилгээний төсвөө боловсруулж батлуулах.
- 5.6 ЭШИХА дэд зөвлөл:
- 5.6.1 Судалгааны дансанд төвлөрсөн орлогоос ЭШИ-ийн ажил санхүүжүүлж хэрэгжүүлэхэд холбогдох шийдвэр, санал зөвлөмж, дүгнэлт гаргах;
- 5.6.2 ШУТИС-иас санхүүжүүлэх төсөл болон бусад арга хэмжээг холбогдох дүрэм, журам, удирдамжийн дагуу сонгон шалгаруулах хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлж хүлээн авах асуудлыг шийдвэрлэх;
- 5.6.3 Гэрээний эрх үүрэг зерчигдсөн, хэрэгжилт хангалтгүй байгаа төсөл, гэрээт ажлыг хэлэлцэж, шаардлагатай санал зөвлөмж, шийдвэр гаргах;
- 5.6.4 ШУТИС-ийн санхүүжилттэй төслийн явцын болон эцсийн тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах.
- 5.7 Дээрх албан тушаалтан, ЭШИ хариуцсан нэгжүүд нь судалгааны орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх, ШУТИС-ийн стратеги зорилтыг хангахуйц үйл ажиллагаанд зарцуулах, энэхүү журмыг их сургуулийн хэмжээнд мөрдүүлэх ажлыг хариуцна.

ЗУРГАА. СУДАЛГААГ ДЭМЖИХ ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР БҮРДҮҮЛЭХ

- 6.1 Судалгааны орлогыг ШУТИС-ийн судалгааг дэмжих дансанд төвлөрүүлнэ.
- 6.2 Судалгааг дэмжих дансны орлогыг дараах эх үүсвэрүүдээс бүрдүүлнэ. Үүнд:
- 6.2.1 ШУТИС-ийн тухайн жилийн төсөвт тусгаж, төвлөрүүлэх замаар; ШУТИС-ийн сургалтын үйл ажиллагааны орлогоос ЭШИ-ийн үйл ажиллагааны санхүүжилтийг дараах байдлаар тооцож бүрдүүлнэ. Үүнд:

№	Суралцаагчдын ЭШ, туршилт судалгааны орлого	Тооцох хувь
1	Бакалаврын сургалтын дадлагын (зохион бүтээх, техник сэтгэлгээг хөгжүүлэх, сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу)	1 кредит
2	Магистрын сургалтын туршилт, судалгааны ажлын (сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу)	3 кредит
3	Докторын сургалтын туршилт, судалгааны ажлын (сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу)	16 кредит

- 6.2.2 ШУТИС-ийн нэрээр гэрээ байгуулан хэрэгжиж буй төсөл, гэрээт ажлын орлогоос тооцох төлбөр;



ШУТИС-ийн хэмжээнд дараах хүснэгтэд дурдсанаар төлбөр тооцно.

№	Төсөл хөтөлбөрийн төрөл	Төлбөр тооцох хувь
1	Энэхүү журмын 4.6.2-т тусгасан ШУТС-гийн санхүүжилттэй төсөл	5 хувь
2	Энэхүү журмын 4.6.3 болон 4.7-д тусгасан төсөл, гэрээт ажил	10 хувь

- 6.2.3 ШУТИС-ийн барааны тэмдэгт ашиглах журамд тусгасан хураамж;
- 6.2.4 Судалгааны үр дүнг эргэлтэд (лицензийн гэрээ, гарцааны компани, роялти) оруулснаас олох орлого;
- 6.2.5 Туршилт, судалгааны төлбөрт үйлчилгээний орлогоос 10 хувь тооцох
- 6.2.6 Хамтын ажиллагаатай байгууллагаас ЭШИГ-т өгсөн хандив, тусlamж;
- 6.2.7 Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр
- 6.3 Төслийн удирдагч, гэрээт ажлын гүйцэтгэгч нь 6.2.2-т заасан их сургуулийн төлбөрийг төсөвтөө тусгаж төсөвлөх үүрэгтэй. Хэрэв төсөвлөөгүй тохиолдолд ШУТИС нь төсөл хэрэгжүүлэхээс татгалзах, эсвэл үл маргах зарчмаар төлбөр тооцож авах эрхтэй.
- 6.4 Хэрэв зээл, хандив, тусlamжаар хэрэгжих төсөл, гэрээт ажлын зардалд аливаа төлбөр, татвар хураамж, шимтгэл төлөхийг тусгайлан хориглосон тохиолдолд ЭШИГ-тай зөвшилцэж, гэрээнд тусгасны үндсэн дээр энэхүү журмын 6.2.2-т заасан төлбөрийн хувийг тооцохгүй.
- 6.5 Төслийн гэрээнд худалдан авах багаж, тоног төхөөрөмжийг ШУТИС-ийн өмч болгооор тусгасан тохиолдолд зарцуулах мөнгөн дүнг төслийн нийт санхүүжилтээс хасч, үлдсэн дүнгээс 6.2.2-т заасан төлбөрийг тооцно.
- 6.6 Жилд 20 сая төгрөгөөс дээш цэвэр мөнгөн орлогыг энэхүү журмын 6.2.2, 6.2.5, 6.2.6-д заасан эх үүсвэрүүдээс судалгааг дэмжих дансанд төвлөрүүлсэн багш судлаач, хувь хүн, төслийн багт төвлөрүүлсэн нийт орлогын 5 хувийг урамшуулал болгон олгоно. Хэрэв ШУТИС-ийн профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журмын дагуу урамшуулал авсан бол давхардуулан олгохгүй.

ДОЛОО. СУДАЛГААГ ДЭМЖИХ САНХҮҮЖИЛТ, ХУВААРИЛАЛТ

- 7.1 Тухайн санхүүгийн жилийн зарцуулалт нь энэхүү журмын 6.2-т заасан нийт бүрдсэн орлогоос хэтрэхгүй байх бөгөөд төсөвт тусгасны дагуу ЭШИ-ийг дэмжихэд чиглэсэн доорх үйл ажиллагаануудад зарцуулна. Үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ холбогдох журам, удирдамжийг баримтална.
- 7.2 ШУТИС-ийн Судалгааны профессорын баг, салбар дундын хамтарсан судалгааны багт судалгааны тэтгэлэг олгох;
 - 7.2.1. Нэг жилд 5-аас илүүгүй судалгааны багт тэтгэлэг олгоно;
 - 7.2.2. Тэтгэлэг авах судалгааны багийг өрсөлдөөнт хэлбэрээр сонгон шалгаруулах бөгөөд, тэтгэлгийг ЭШИГ-аас гэрээ байгуулан санхүүжүүлнэ.
- 7.3 ШУТИС-ийн "Шилдэг бүтээл" сонгон шалгаруулж, урамшуулах;
 - 7.3.1 Багш судлаачдын "Шилдэг бүтээл"-ийн шалгаруулалтыг жил бүрийн 1 дүгээр сард зарлаж, тухайн жилийн 10 дугаар сард сонгон шалгаруулан урамшуулах бөгөөд олон нийтэд сурталчлах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:



- Олон улсад хэвлүүлсэн Шилдэг эрдэм шинжилгээний ёғүүлэл (олон улсын мэргэжлийн сэтгүүлд судалгааны ажлын үр дүнгээ ШУТИС-ийн нэр дээр хэвлүүлсэн тус их сургуулийн багш, судлаачдын бүтээл)
 - Шилдэг бүтээл (онол практикийн ач холбогдол бүхий аж үйлдвэрийн оюуны өмч болж хөгжиж болохуйц, шинжлэх ухаан, технологийн бүтээл)
 - Шилдэг технологи (оюуны өмч /аж үйлдвэр өмч/-ийн эрхээр баталгаажсан, үйлдвэрлэл хэрэглээнд нэвтрэх боломжтой технологи)
- 7.4 Докторын дараах судалгааны (Post-doc) тэтгэлэг олгох;
- 7.4.1 Нэг жилд 5 хүртэлх ШУТИС-ийн үндсэн орон тооны багш, судлаачдыг сонгож, тэтгэлэг олгоно.
- 7.4.2 Нэг судлаачид олгох тэтгэлгийн нийт хэмжээ 10 сая хүртэлх төгрөг байна.
- 7.4.3 Докторын дараах тэтгэлгийг ШУТИС-ийн судалгааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд санхүүжүүлнэ.
- 7.5 Зочин судлаачдад судалгааны тэтгэлэг (Fellowship) олгох;
- 7.5.1 Зочин судлаачийн судалгааны тэтгэлгийг их сургуулийн судалгааг хөгжүүлэх, багш судлаачдын чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор зарлана.
- 7.5.2 Зочин судлаачийн судалгааны тэтгэлэг хүртэгч нь гадаад орны их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын судалгаа, инноваци, технологийн өндөр үр чадвартай судлаач байх бөгөөд ШУТИС-ийн залуу судлаачдыг дагалдуулан, эрдмийн зэрэг хамгаалуулах чиглэлд үйл ажиллагаагаа уялдуулна.
- 7.6 Нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий тодорхой үр дүн, хүлээлтэд хүрэх асуудал шийдвэрлэх судалгааны төсөл хөтөлбөр;
- 7.6.1 ШУТИС-ийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлийн хүрээнд суурь судалгаа, захиалгат ажил болон технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төслийг жилд нэг удаа зарлаж санхүүжүүлнэ.
- 7.6.2 Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх, ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд чиглэсэн технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төслийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр бусад төслийг буцалтгүй санхүүжүүлнэ.
- 7.6.3 Төслийн сонгон шалгаруулалтыг хичээлийн жилийн эхэнд (9 дүгээр сар) зарлаж, 12 дугаар сард сонгон шалгаруулна.
- 7.7 Судалгааны ажлын үр дүнг олон улсын мэдээллийн сан (WoS, Scopus)-д бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх болон оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийх;
- 7.7.1 ШУТИС-ийн үндсэн орон тооны багш, харьяа хүрээлэнгийн эрдэм шинжилгээний судлаачид судалгааны үр дүнгээ олон улсын мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлэх зардлыг жилд нэг удаа олгоно.
- 7.7.2 ШУТИС-ийн дангаараа болон бусадтай хамтран эзэмших оюуны өмчийг мэдүүлэх зардлыг санхүүжүүлнэ.
- 7.7.3 Энэхүү журмын 7.7.1, 7.7.2-т заасан
- 7.7.4 зардлыг төслийн гэрээний зардалд тусгагдсан тохиолдолд давхардуулж олгохгүй.
- 7.8 ШУТИС-ийн эзэмшил бүхий оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн гарааны хөрөнгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжүүлэх;
- 7.8.1 Үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх боломжтой инновацийн шийдэл бүхий оюуны бүтээлд технологи дамжуулах журмын дагуу гарааны компани байгуулах, хөгжүүлэх, технологи лицензлэхтэй холбоотой санхүүжилт олгоно.



- 7.8.2 Гарааны санхүүжилтийн хэмжээг тухайн жилийн төсвээс хамааруулан тогтоох бөгөөд 3 жилээс хэтрэхгүй эргэн төлөгдөх нөхцөлтэй байна.
- 7.9 ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл, сэтгүүлийг хэвлэн нийтлэх, эрхлэн гаргах зардал;
- 7.9.1 ШУТИС-иас эрхлэн гаргаж буй олон улсын ISSN дугаартай эрдэм шинжилгээний (хэвлэмэл болон онлайн) сэтгүүлийн хэвлэлт, эрхлэн гаргах зардлыг санхүүжүүлнэ.
- 7.10 Олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, семинар, үзэсгэлэнд оролцох, зохион байгуулах, мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн төлбөр;
- 7.10.1 ШУТИС-ийн нэгжүүдийн ЭШИ-ийн төлөвлөгөөнд тусгагдсан, хурал семинар, үзэсгэлэн, арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ.
- 7.11 Судалгаа, инновацийг дэмжихэд чиглэсэн технологи зохион бүтээх уралдаан, стартап энтрепренёр хөтөлбөр хэрэгжүүлэх;
- 7.11.1 ШУТИС-ийн хэмжээнд оюуны өмчийн эрхийн хамгаалалт, энтрепренёр боловсрол олгох үйл ажиллагаа, хөтөлбөрийг санхүүжүүлнэ.
- 7.11.2 Багш, суралцагчдын гарааны бизнес, техник сэтгэлгээг хөгжүүлэх таатай орчин (бизнес инкубатор, хамтын оффис) бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 7.11.3 ШУТИС-ийн Судалгааны тэргүүлэх чиглэлээр суралцагсдын дунд технологи, зохион бүтээх, шинэ санааг хэрэгжүүлэх, бойжуулахад чиглэсэн өрсөлдөөнт тэтгэлэгт хөтөлбөрийг удирдамжийн дагуу зохион байгуулна.
- 7.12 Судалгааны төв, лабораториудын үйл ажиллагааг дэмжих, санхүүжилт олгох;
- 7.12.1 Их сургуулийн судалгааны лабораторийг дотоодод болон олон улсад магадлан итгэмжлүүлэх болон бусад зардалд дэмжлэг үзүүлнэ.
- 7.13 ЭШИ-ийн чиг үүргийг хэрэгжүүлэх, зохион байгуулахтай холбоотой зардал.

НАЙМ. ТӨСӨЛ, ГЭРЭЭТ АЖИЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

- 8.1 ШУТИС-ийн нэр дээр гэрээ байгуулсан төслийг хэрэгжүүлэх, үр дунг хүлээлгэн өгөх үйл ажиллагааг энэхүү бүлэгт заасны дагуу зохицуулна.
- 8.2 Төслийн гэрээ байгуулах, баталгаажуулах
- 8.2.1 ШУТИС-ийн нэгжүүдийн (харьяа хүрээлэн хамаарахгүй) байгуулах 50 сая төгрөгөөс дээш санхүүжилттэй төсөл, гэрээт ажлын гэрээнд зөвхөн Их сургуулийн Захирал эсвэл ЭШИХЭ дэд захирал, 50 сая төгрөгөөс бага дунтэй гэрээнд Бүрэлдэхүүн сургууль, судалгааны төвийн захирал гарын үсэг зурж баталгаажуулна.
- 8.2.2 Энэхүү журмын 4.6.2-т заасан төслийн гэрээг их сургуулийн ЭШХАЭ дэд захирал баталгаажуулна. *
- 8.2.3 Төслийн удирдагч, гэрээт ажлын гүйцэтгэгч нь гэрээ байгуулахдаа энэхүү журамд заасан гэрээ байгуулах маягтын дагуу гэрээт батлуулна.
- 8.2.4 Их сургуулийн нэрийг ашиглан гэрээ байгуулж үйл ажиллагаа явуулан санхүүжилтийг нуун дарагдуулсан тохиолдолд ШУТИС-ийн хөдөлмөрийн дотоод журмын 10.3-т заасны дагуу буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэнэ.
- 8.3 Төсөл, гэрээт ажлыг эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн системд бүртгэх



- 8.3.1 Төсөл удирдагч нь гүйцэтгэгч багийг бүрдүүлж, төслийн ажлын даалгавар, түүнийг хийж гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөөг бүрэлдэхүүн сургууль, харьяа хүрээлэнгийн эрдмийн зөвлөлд танилцуулж арга зүйг батлуулна.
- 8.3.2 Шинээр эхэлж буй төсөл, гэрээт ажлын мэдээллийг ЭНБД “Эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн систем”-д төслийн гэрээ батлагдсанаас хойш 1 сарын дотор бүртгэж оруулна.
- 8.4 Төслийг хэрэгжүүлэх, хяналт тавих
 - 8.4.1 Хэрэв судалгааг дэмжих дансанд төсөл, гэрээт ажлын орлого орсон тохиолдолд энэхүү журмын 6.2.2-т заасан төлбөрийг суутгаж, санхүүжилтийг хэрэгжүүлэгч бүрэлдэхүүн сургууль, харьяа хүрээлэнгийн дансанд ажлын 3 хоногийн дотор шилжүүлнэ.
 - 8.4.2 Төсөл, гэрээт ажлын удирдагч нь гэрээнд заасан графикийн дагуу санхүүжилтээ авч, судалгааны ажлаа хэрэгжүүлнэ.
 - 8.4.3 Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн ахлах нягтлан бодогч нь төслийн санхүүгийн бүртгэл, тайлан тооцоог зохих журмын дагуу гаргаж, тайлагнах үүргийг хүлээнэ. Тухайн төсөл, гэрээт ажлын орлого, зардлыг төсөвт тусгаж төлөвлөх үүрэгтэй.
 - 8.4.4 ШУТИС-ийн нэрээр байгуулсан төсөл, гэрээт ажлыг хэрэгжүүлэхэд их сургуулийн болон тухайн нэгжийн ажлын өрөө, сургалтын анги танхим, судалгааны лабораторийн бараж, тоног төхөөрөмж, компьютер болон бусад техник хэрэгслийг ашиглаж болно.
 - 8.4.5 Төслийн явц, эцсийн үр дүнг бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр хагас жил тутам хэлэлцүүлж, шалгах хуудсаар дүгнүүлнэ.
 - 8.4.6 Төслийн удирдагч нь тухайн төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн мэдээллийг хагас жил тутам (6, 12 дугаар сар) “Эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн систем”-д оруулах бөгөөд ЭНБД нар хянаж, эрдмийн зөвлөлийн дүгнэлтийг хавсарган баталгаажуулна.
 - 8.4.7 ЭШИГ нь ШУТИС-ийн хэмжээнд хэрэгжиж буй төслийн тайлан дүн мэдээг нэгтгэж, гэрээний эрх үүрэг зөрчигдсөн хэрэгжилт хангалтгүй байгаа төслийг ШУТИС-ийн ЭШИХА-ны дэд зөвлөлөөр хэлэлцүүлж, шаардлагатай шийдвэрийг гаргуулна.
- 8.5 Төслийн үр дүнг хэлэлцэж, хүлээлгэн өгөх
 - 8.5.1 Төслийн үр дүнгийн хэлэлцүүлгийг тухайн бүрэлдэхүүн сургууль, харьяа хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, дүгнүүлэх бөгөөд дүгнэлтийг үндэслэн гэрээг баталсан эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан захиалагч, санхүүжүүлэгч байгууллагад хүргүүлнэ.
 - 8.5.2 ШУТИС-иас санхүүжүүлсэн төслийн явцын болон эцсийн тайланг ЭШИХА дэд зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дүгнүүлэн ЭШИГ-т хүлээлгэж өгнө.
 - 8.5.3 Гэрээт ажлын үр дүнг гүйцэтгэгч, захиалагчтай байгуулсан гэрээний дагуу харилцан тохиролцсон хэлбэрээр хүлээлгэн өгч, гэрээ дүгнэсэн актыг тухайн нэгжийн ЭНБД “Эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн систем”-д оруулна.
 - 8.5.4 Төсөл хэрэгжүүлсний үр дүнд бий болсон үндсэн хөрөнгө, оюуны өмчийг гэрээнд заасны дагуу эзэмшинэ.
 - 8.5.5 Төслийн удирдагч гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө төслийн үр дүн, санхүүгийн гүйцэтгэлийн тайланг захиалагчид актаар хүлээлгэж өгнө. Тус



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн
20.04.2004 дугээр сарын 29.-ний өдрийн
1145 дугаар тушаалын хавсралт

актын нэг хувийг ЭШИГ-т ирүүлснээр эцсийн тайланг хүлээлгэн өгөх үйл явц
дуусгавар болно.

- 8.5.6 Дуусгавар болсон төслийн үр дүн, мэдээллийг ЭШИГ хариуцан “Эрдэм
шинжилгээний мэдээллийн нэгдсэн систем”-д бүртгэж, цахим архив үүсгэнэ.

ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1 Журмын хэрэгжилт, зохион байгуулалт, хяналтыг ЭШИГ, ТДТ хариуцан явуулна.
- 9.2 Энэхүү журмын заалтуудыг зөрчсөн тохиолдолд буруутай этгээдэд их сургуулийн
холбогдох дүрэм, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 9.3 Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн зөрчил, маргааныг аль болох харилцан
зөвшилцэж шийдвэрлэхийг эрмэлзэх ба боломжгүй тохиолдолд холбогдох хууль
тогтоомжийн хүрээнд шүүхээр шийдвэрлүүлнэ.



ХАВСРАЛТ 1: СУДАЛГААГ ДЭМЖИХ САНХҮҮЖИЛТИЙГ БҮРДҮҮЛЭХ, ТӨСӨВЛӨХ, ЗАРЦУУЛАХ ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ

Оролцооны тайлбар: [R] - Хариуцан хийж, гүйцэтгэх; [A] - Тухайн алхамд хариуцлага хүлээх, батлах; [C] - Тухайн алхмыг гүйцэтгэхдээ зөвлөлдөх, хамтрас оролцох; [I] – Алхмын гаралтыг мэдээлэх

№	Оролт	Үйл явц	Гаралт	Оролцоо (RACI)				
				ЭШИХН	Судлаач	Няглан бодогч	ЭШИХ дэд зөвлөл	ЭШХАЭД дэд захирал
1	Тус журмын 6.2 дахь заалтууд		Судалгааны орлого	C		R		A
2	Судалгааны орлого	2. ЭШИ-ийн төлөвлөгөө, төсөв боловсруулах	ЭШИ-ийн ү.аж-ны төсөв, төлөвлөгөө	R		R		A
3	ЭШИ-ийн ү.аж-ны төсөв, төлөвлөгөө	3. Төлөвлөсөн сонгон шалгаруулалт зарлах	• Журам • Удирдамж • Зарлал	R		C	C	A
4	• Журам • Удирдамж • Зарлал	4. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах	Шалгарсан төсөл, тэтгэлэг, хетелбэр	C	I	C	R	A
5	Шалгарсан ЭШИ үйл ажиллагаа	5. Талууд гэрээг зөвшилцэн байгуулах	Баталгаажсан гэрээ	R	C	C		A
6	Баталгаажсан гэрээ	6. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих	Хяналтын хуудас	C	R	C	A	I
7	Явцын тайлан	7. Хэрэгжилтийг дүгнэж, гэрээг хаах	Гэрээг дүгнэж, тайлан хүлээнцсэн акт	C	R	C	A	C
8	Гэрээг дүгнэсэн акт	8. ЭШИ-ийн үйл ажиллагааны мэдээллийн санг үүсгэж, хадгалах	ЭШИ цахим сан	R	C	C		A



ШУТЫС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн
20²⁹ оны 09 дүгээр сарын 29.-ний өдрийн
1145 дугаар тушаалын хавсралт

Тайлбар:

- * ЭШИХН – Эрдэм шинжилгээ, инноваци хариуцсан нэгжийн үүрэг оролцоонд ЭШИГ, ТДТ, бүрэлдэхүүн нэгжүүдийн ЭНБД нарыг;
- * Судлаач – Судлаачийн үүрэг оролцоонд ЭШИ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй профессор, багш судлаач, төслийн баг, зочин профессор, гарааны компани зэргийг төлөөлүүлэн ойлгоно.

ХАВСРАЛТ 2: ХОЛБОГДОХ МАЯГТ

№	Маягтын нэр	Маягтын дугаар	Хадгалах эзэн/байршил
1	Сонгон шалгаруулалтын хуудас	ЭШ-М010	
2	Төсөл, гэрээт ажлын гэрээ байгуулах хуудас	ЭШ-М011	
3	Гэрээний маягт	ЭШ-М012	
4	Төслийн гүйцэтгэлийн хяналтын хуудас	ЭШ-М013	
5	Төслийн гэрээг дүгнэж, тайлан хүлээлцсэн акт	ЭШ-М014	

Маягт: ЭШ-М010

Сонгон шалгаруулалтын хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ	Тайлбар
1			
2			
3			

Гарын үсэг:

Эрдмийн дэд зөвлөлийн гишүүн: _____ / _____ Гарын үсэг / Овог, нэр

Маягт: ЭШ-М011

Төсөл, гэрээт ажлын гэрээ байгуулах хуудас

№	Албан тушаал	Он, сар, өдөр	Санал	Гарын үсэг
1	Гэрээг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтан (ЭШХАЭ дэд захирал эсвэл тухайн нэгжийн захирал)			
2	Санхүү (ЭШХА нягтлан бодогч эсвэл БНА нягтлан бодогч)			
3	Эрдэм шинжилгээ (ЭШИХН-ийн төсөл хариуцсан мэргэжилтэн эсвэл ЭНБД)			



Маягт: ЭШ-М012

Гэрээний маягт

ШУТИС-ИЙН СУДАЛГААГ ДЭМЖИХ ДАНСНААС ТӨСӨЛ САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

20..... оны сарын-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Санхүүжүүлэгч: ШУТИС-ийг төлөөлж Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал

Гүйцэтгэгч: Гүйцэтгэгч нэгжийг төлөөлж /сургууль, хүрээлэнгийн захирал/

Төслийн удирдагч: ШУТИС-ийн
(доктор, профессор)

нар /цаашид “талууд” гэх/ “ШУТИС-д Төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”, ШУТИС-ийн захирлын 20... оны ... дүгээр сарын-ны өдрийн тоот тушаалыг үндэс болгон “.....” төсөл /цаашид “төсөл” гэх/-ийг эргэн төлөгдөх/төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр гүйцэтгэхээр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Төслийг 20.... оны сарын-ний өдрөөс 20.... оны сарын-ний өдөр хүртэл жилд багтааж гүйцэтгэнэ.
- 1.2 Төслийн санхүүжилт 19,800,000 (арван есөн сая найман зуун мянга) төгрөг.
- 1.3 Төслийн хүрээнд гүйцэтгэх ажлын дараалал, төслөөр гарах үр дүнгийн даалгаврыг нэгдүгээр, төслөөр гүйцэтгэх ажлын календарчилсан төлөвлөгөөг хоёрдугаар, төслийн өртөг, зардал тохиролцсон тухай протоколыг гуравдугаар, төслийн картыг дөрөвдүгээр, эрдэм шинжилгээний зардлын задаргааны маягтыг тавдугаар хавсралтын дагуу тус тус үйлдэж гэрээнд хавсаргав. Эдгээр хавсралт нь гэрээний нэг бүрдэл хэсэг болж гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр байна.
- 1.4 Шинээр эхэлж буй төслийн мэдээллийг төслийн удирдагч тухайн гүйцэтгэгч байгууллага /бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн/-ын захирлын зөвлөлд албан ёсоор танилцуулах ба энэ талаар тухайн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн даргын тодорхойлолтыг үндэслэн төслийн санхүүжилт олгогдож эхэлнэ.
- 1.5 Төслийн үр дүнд буй болсон оюуны бүтээл, өмчийг ШУТИС-ийн Технологи дамжуулах журмын хүрээнд зохиогч нь судлаач, эзэмшигч нь ШУТИС байх бөгөөд их сургуулийн оюуны өмчийн мэдээллийн баазад бүртгүүлнэ.
- 1.6 Төсөл хэрэгжүүлэх явцад түүний санхүүжилтийн хэмжээ, хугацаанд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарвал талуудын хооронд нэмэлт гэрээ байгуулж хавсаргана.
- 1.7 Төслийн зардлаар бий болсон үндсэн хөрөнгө /багаж, төхөөрөмж, компьютер гэх мэт-/ийг төсөл дууссанаас хойш гүйцэтгэгч байгууллагын өмчид бүртгэж ашиглана.



Хоёр. Талуудын үүрэг

- 2.1. Санхүүжүүлэгч дор дурдсан үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 2.1.1 Төслийн батлагдсан зардлыг гэрээнд заасан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлэх;
 - 2.1.2 Төслийн гүйцэтгэл, хөрөнгө зардлын зарцуулалтад байнгын хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
 - 2.1.3 Төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар тухайн гүйцэтгэгч байгууллагын эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн тайланг хагас жил тутам гаргуулан авч түүнийг үндэслэн дараагийн үе шатны санхүүжилтийг олгох /зогсоо/;
 - 2.1.4 Төслийн үр дүн, тайланг ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газар хүлээн авч хянан, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөлөөр хэлэлцүүлэн, зөвлөлийн санал дүгнэлтийг үндэслэн гэрээг дүгнэх;
 - 2.1.5 Төлөвлөсөн үр дүнд холбогдолгуй ажлыг төслийн хүрээнд гүйцэтгэх, төслийн хэрэгжилтийн явц удаашрах, төлөвлөсөн ажил биелэгдэхгүй байх, үр дүн нь хэрэгцээ шаардлагыг хангахгүй болсон тохиолдолд төслийн санхүүжилтийг зогсоо, гэрээг цуцлах, хариуцлага тооцоо асуудлыг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөлтэй хамтран ШУТИС-ийн Захиргааны зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх;
 - 2.1.6 Төслийн үр дүнг хүлээн авч түүнийг үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах.
- 2.2. Гүйцэтгэгч дор дурдсан үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 2.2.1 Шинээр эхэлж буй төслийг бүртгэж, өөрийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох санал, зөвлөмжийг төслийн удирдагчид өгөх;
 - 2.2.2 "ШУТИС-д Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, гэрээт ажил гүйцэтгэх журам"-ын 2-р хавсралтын дагуу төслийн санхүүжилтийн задаргааг хянаж батлах ;
 - 2.2.3 Төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүй, удирдлага зохион байгуулалт, лаборатори тоног төхөөрөмжөөр дэмжин ажиллах;
 - 2.2.4 Төслийн явц, үр дүнг хагас жил тутам Эрдмийн зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлж холбогдох дүгнэлтийг санхүүжүүлэгчид хүргүүлж байх;
 - 2.2.5 Төслийн үр дүн хэрэгжээгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд ШУТИС-ийн Технологийн сангийн журмын 7.3-т заасны дагуу үүрэг хүлээнэ.
- 2.3. Төслийн удирдагч дор дурдсан үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 2.3.1 Төслийг гэрээт хугацаанд багтааж бүрэн гүйцэтгэх, үр дүнг тоо, чанарын хувьд захиалсан түвшингээс бууруулахгүйгээр бүтээж бий болгох;
 - 2.3.2 Төслийн хөрөнгө зардлыг оновчтой хэлбэрээр хуваарилж, үр ашигтай зарцуулах;
 - 2.3.3 Төслийн хэрэгжилтийн талаар санхүүжүүлэгчийн шаардсан мэдээ, материалыг цаг тухайд нь гаргаж өгөх;
 - 2.3.4 Санхүүжилтийн гүйцэтгэл, төслийн явцыг хагас жил тутам тайлagnаж байх;
 - 2.3.5 Гүйцэтгэж буй төслийн ажлын үр дүнг сурталчилж байх, түүнийг нэвтрүүлэх буюу ашиглах аж ахуйн нэгж байгууллагыг олох;
 - 2.3.6 Дууссан төслийн тайланг ШУТИС-д Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, гэрээт ажил гүйцэтгэх журмын 5.3, 7.5-т заасны дагуу хүлээлгэн өгөх;
 - 2.3.7 Төслийг хэрэгжүүлж дууссаны дараа санхүүгийн өр авлагын тооцоог бүрэн гүйцэд хийж барагдуулах;



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн
2022 оны 04 дугаар сарын 29-ний өдрийн
A/45 дугаар тушаалын хавсралт

- 2.3.8 Төслийн үр дүн хэрэгжээгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд ШУТИС-ийн Технологийн сангийн журмын 7.3-т заасны дагуу үүрэг хүлээнэ.

Гурав. Талуудын эрх

- 3.1. Санхүүжүүлэгч дор дурдсан эрх эдэлнэ. Үүнд:

- 3.1.1 Төслийн гүйцэтгэл, үр дүн, санхүүгийн үйл ажиллагаа зэрэг асуудлын талаар гүйцэтгэгчээс тухай бүр мэдээ, тайлан гаргуулж авах, гэрээний үүргийг биелүүлэх, зөрчил дутагдлыг арилгах талаар анхааруулах, шаардлага тавих;
- 3.1.2 Гэрээний шаардлагыг хангаагүй үр дүнг хүлээж авахгүй байх, уг ажлыг дахин гүйцэтгүүлэх, эсвэл олгосон хөрөнгийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах;
- 3.1.3 Төслийн эрдэм шинжилгээний тайланг өмчлөх, бусдад ашиглуулах асуудлыг шийдвэрлэх;
- 3.1.4 Төслийн үр дүнгийн борлуулалт, нэвтрүүлэлтээс олсон орлого, ашгаас ШУТИС-ийн Технологийн санд зохих хэмжээний шимтгэл авах;
- 3.1.5 Төслийн үр дүн нь хэрэгцээ шаардлагыг хангахааргүй төлөвтэй байгаа тохиолдолд төслийн санхүүжилтийг зогсоо буюу шинэчлэх, гэрээг цуцлах.

- 3.2. Гүйцэтгэгч дор дурдсан эрх эдэлнэ. Үүнд:

- 3.2.1 Тухайн бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлаар Төслийн хэрэгжилт, үр дүн хангалтгүй гэж дүгнэгдсэн тохиолдолд төслийг зогсоох, гэрээг цуцлах саналыг санхүүжүүлэгчид хүргүүлэх;
- 3.2.2 Төслийн зардлаар бий болсон үндсэн хөрөнгө (багаж, төхөөрөмж, компьютер гэх мэт)-ийг төсөл дууссанаас хойш өөрийн өмчид бүртгэж, ашиглах

- 3.3. Төслийн удирдагч дор дурдсан эрх эдэлнэ. Үүнд:

- 3.3.1 Төслийн үйл ажиллагааны хүрээнд санхүүжүүлэгч, гүйцэтгэгч талуудаас удирдлага, зохион байгуулалтын хувьд зохих хэмжээний дэмжлэг туслалцаа авах;
- 3.3.2 Төслийг гүйцэтгэх нөхцөл бололцоогоор бүрэн хангахыг шаардах;
- 3.3.3 Төслөөр бий болсон үр дүн нь шинэ бүтээлийн патент авсан нөхцөлд санхүүжүүлэгчтэй лицензийн гэрээ байгуулах үндсэн дээр тухайн үр дүнг ашиглах;
- 3.3.4 Төслийн үр дүнг үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглах явцад зохиогчийн хяналт тавих;
- 3.3.5 Их сургуулийн болон тухайн нэгжийн ажлын өрөө, сургалтын анги танхим, судалгааны лабораторийн багаж, тоног төхөөрөмж, компьютер болон бусад шаардлагатай техник хэрэгслүүдийг ашиглах.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь холбогдох дүгнэлтээр тогтоогдсон бол буруутай тал нь зохих хууль тогтоомж, дүрэм, журам болон энэхүү гэрээний заалтуудыг үндэслэн хариуцлага хүлээж, гарсан хохирлыг бүрэн барагдуулна;
- 4.2. Төслийн удирдагч төслийг хэрэгжүүлээгүй, хариуцлагагүй хандсан, төслийн үр дүнг гаргаж тайлагнаагүй, төслийн хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан, гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд гарсан хохирлыг бүрэн барагдуулна;
- 4.3. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих түвшинд биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын 5



хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд хүндэтгэх шалтгааныг харгалзана;

Тав. Бусад зүйл

- 5.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь холбогдох дүгнэлтээр тогтоогдсон бол буруутай тал нь зохих хууль тогтоомж, дүрэм, журам болон энэхүү гэрээний заалтуудыг үндэслэн хариуцлага хүлээж, гарсан хохирлыг бүрэн барагдуулна;
- 5.2. Гэрээг Монгол хэл дээр З хувь үйлдэнэ. Тал тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн ижил хүчинтэй.
- 5.3. Гэрээний гүйцэтгэлийн явцад аль нэг тал нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа бичгээр мэдэгдэх бөгөөд саналыг хүлээн авсан тал ажлын 5-аас доошгүй хоногийн дотор хариуг бичгээр мэдэгдэнэ.
- 5.4. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт нь гагцхүү бичгээр үйлдэгдэж, талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөрт тооцогдоно.
- 5.5. Оруулсан нэмэлт, өөрчлөлт болон гэрээний хавсралтууд нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг мөн.
- 5.6. Талууд энэхүү гэрээнд дурдаагүй асуудлыг шийдвэрлэхэд Монгол улсын хууль тогтоомжийг удирдлага болгоно.
- 5.7. Энэ гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд тийнхүү тохиролцож чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Санхүүжүүлэгчийг
төлөөлж:

Гүйцэтгэгч байгууллагыг Төслийн удирдагч:
төлөөлж:

.....
.....
ШУТИС-ийн ЭШХА эрхэлсэн
дэд захирал

.....

.....
.....
сургуулийн захирал

.....
.....
ШУТИС-ийн доктор, дэд
профессор

Маягт: ЭШ-М013

Төслийн гүйцэтгэлийн хяналтын хуудас

№	Төслийн нэр	Төслийн удирдагч	Үр дүнгийн даалгаврын биелэлт	Төслийн зардлын гүйцэтгэл	Үр дүн /ЭШӨ, оюуны өмч, стандарт г.м/	ШУТИС-д оруулсан хувь нэмэр	Нийт оноо
			Дүгнэх оноо 0 – 40	Дүгнэх оноо 0 – 20	Дүгнэх оноо 0 – 20	Дүгнэх оноо 0 – 20	Нийлбэр оноо 0 – 100
1							

Гарын үсэг: Эрдмийн зөвлөлийн гишүүн: _____ / _____ /



Гарын үсэг

Овог, нэр

Харгалзах оноог доорх үнэлгээний хувьд үндэслэн коэффициентэлж тооцно уу.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолд заасан үнэлгээний хувь:

- “Үр дүнтэй”- төслийн зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь;
- “Тодорхой үр дүнд хүрсэн”- төслийн зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарсан, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70-99 хүртэл хувь;
- “Эрчимжүүлэх шаардлагатай”- төслийн зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай бол 31-69 хүртэл хувь;
- “Үр дүнгүй”- төслийн зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0-30 хүртэл хувь.



Маягт: ЭШ-М014

Төслийн гэрээг дүгнэж, тайлан хүлээлцсэн акт

ТӨСЛИЙН ГЭРЭЭГ ДҮГНЭЖ, ТАЙЛАН ХҮЛЭЭЛЦСЭН АКТ

ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөлийн 20.... оны сарын өдрийн дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн тоот гэрээтэй - онд хэрэгжүүлсэн “.....” нэртэй ажлын тайланг гүйцэтгэгчэс санхүүжүүлэгчид хүлээлгэн өгч-нд энэхүү актыг үйлдэв.

Төслийн үр дүнг үнэлж, хүлээн авсан актын дугаар:

..... төсөл
Төслийн төрлийг бичих

Төслийн үр дүн			
Үр дүнгийн үзүүлэлт	тоо	Үр дүнгийн үзүүлэлт	тоо
Ном:		ТЭЗҮ:	
Шинэ бүтээл:		Газрын зураг:	
Шинэ технологи:		Шинэ онол:	
Стандарт:		Өгүүлэл дотоод:	
Зөвлөмж:		Өгүүлэл гадаад:	
Заавар:		Илтгэл гадаад:	
Патент:		Илтгэл дотоод:	
Ашигтай загвар:		Аргачлал:	
Зохиогчийн эрх:		Үр ашиг:	
		Эшлэл:	

Хуудасны тоо:

Зургийн тоо:

Хүснэгт:

График:

Схем:

Хавсралт:

Тайлан өмчлөгч: Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль

Санхүүжүүлэгч: ШУТИС-ийн Судалгааг дэмжих данс (ЭШИГ)

Итгэмжлэн хадгалагч: ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газар

Төслийн удирдагч: (эрдмийн зэрэг, цол)

Хүлээн авсан: / /
Хүлээлгэн өгсөн: / /